



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/45/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022-02-24 № 12/105

ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭГМИД ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020490

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name 'Б.Мөнхбат' and the title 'Аудитор'. The signature is written in a cursive style.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,374,526.00	136,516,623.90
33	АВЛАГА	12,860,664.00	95,725.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	47,664.00	95,725.00
335	Бусад авлага	12,813,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	12,813,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,513,862.00	136,420,898.90
351	Түүхий эд материал	996,400.00	14,602,633.90
35110	Тусгай зориулалттай материал	00.00	13,085,218.90
35130	Эм боох материал	996,400.00	1,517,415.00
354	Хангамжийн материал	106,517,462.00	121,818,265.00
35410	Бичиг хэргийн материал	1,101,780.00	2,323,500.00
35420	Аж ахуйн материал	88,222,582.00	97,930,107.00
35450	Барилгын засварын материал	13,209,850.00	6,848,950.00
35460	Хүнсний материал	2,250.00	1,248,835.00
35470	Бусад хангамжийн материал	3,981,000.00	13,466,873.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,720,551,324.10	1,726,803,944.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,720,551,324.10	1,726,803,944.94
392	Биет хөрөнгө	1,682,459,113.38	1,688,803,944.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,564,327,979.00	1,577,421,547.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,074,770.36	-63,820,362.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,799,999.96	-5,599,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,220,573.27	211,387,773.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-118,380,969.14	-138,203,686.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,179,852.22	168,623,852.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,360,789.85	-100,378,296.53
39217	Ном	10,347,238.20	11,373,118.20
393	Биет бус хөрөнгө	38,092,210.72	38,000,000.00
39301	Програм хангамж	352,600.00	352,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-260,389.28	-352,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	38,000,000.00	38,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,840,925,850.10	1,863,320,568.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	610,761.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	610,761.00	00.00
413	Өглөг	610,761.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	610,761.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,840,315,089.10	1,863,320,568.84
51	Засгийн газрын хувь оролцоо	1,840,315,089.10	1,863,320,568.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,308,640,649.12	1,308,640,649.12
51101	Өмч: - төрийн	1,308,640,649.12	1,308,640,649.12
512	Хуримтлагдсан үр дүн	-3,578,568.82	257,404,761.02
51210	Өмнөх үеийн үр дүн	-3,578,568.82	234,399,281.28
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	23,005,479.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	535,253,008.80	297,275,158.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,840,925,850.10	1,863,320,568.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,196,904,621.00	1,036,358,177.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,551,091.00	45,105,991.90
120	Нийтлэг татварын бус орлого	210,551,091.00	45,105,991.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	210,551,091.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	210,551,091.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	26,494,448.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	16,611,543.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,353,530.00	991,252,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	842,619,300.00	828,406,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	842,619,300.00	828,406,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,619,430.00	37,255,531.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,759,430.00	37,255,531.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,860,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,114,800.00	125,590,555.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,114,800.00	125,590,555.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	973,026,642.44	1,013,352,698.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,026,642.44	1,013,352,698.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	906,973,644.44	932,534,392.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,558,391.00	620,143,042.00
210101	Үндсэн цалин	567,696,969.00	578,078,097.00
210104	Урамшуулал	32,861,422.00	42,064,945.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,763,031.00	81,038,084.00
210201	Тэтгэврийн даатгал	51,480,978.00	78,936,855.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,621,617.00	486,462.00
210203	ҮОМШО-ний даатгал	3,545,710.00	306,825.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,075,837.00	93,097.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,038,889.00	1,214,845.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,022,992.00	124,841,355.00
210301	Гэрэл, цахилгаан	4,239,992.00	3,842,655.00
210302	Түлш, халаалт	111,727,000.00	120,635,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	363,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,911,795.00	4,436,594.00
210401	Бичиг хэрэг	2,733,600.00	866,780.00
210402	Тээвэр, патахуун	4,408,150.00	1,320,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	759,277.00	860,374.00
210404	Ном, хэвлэл	54,000.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	509,268.00	638,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,204,700.00	732,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	242,800.00	00.00
2105	Нормативт зардал	20,842,200.00	20,482,215.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	726,900.00	538,185.00
210502	Хоол, хүнс	20,115,300.00	18,742,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,202,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,086,800.00	9,150,600.00
210604	Урсгал засвар	8,086,800.00	9,150,600.00
2107	Томилголт, зочны зардал	1,448,000.00	650,000.00
210702	Дотоод албан томилголт	1,448,000.00	650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,767,600.00	4,818,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,067,600.00	4,318,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,572,835.44	66,974,402.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,355,699.00	4,718,075.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,323,622.00	778,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	61,893,514.44	61,478,027.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,052,998.00	80,818,306.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,738,330.00	51,769,523.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,289,100.00	20,169,215.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,905,408.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,759,430.00	23,238,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,689,800.00	456,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,860,000.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,860,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,808.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,808.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,290,860.00	29,048,783.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,290,860.00	29,048,783.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	223,877,978.56	23,005,479.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	223,877,978.56	23,005,479.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	986,353,530.00	993,252,186.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,353,530.00	991,252,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	842,619,300.00	828,406,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	842,619,300.00	828,406,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,619,430.00	37,255,531.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,759,430.00	37,255,531.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,860,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,114,800.00	125,590,555.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,114,800.00	125,590,555.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	986,353,530.00	976,035,986.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	986,353,530.00	976,035,986.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,199,712.00	896,690,215.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600,050,781.00	619,737,107.00
210101	Үндсэн цалин	475,777,384.52	406,747,609.00
210102	Нэмэгдэл	73,858,387.02	171,125,573.00
210104	Урамшуулал	50,415,009.46	41,863,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,389,548.00	82,102,841.00
210201	Тэтгэврийн даатгал	51,890,528.00	65,424,341.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,814,442.00	4,254,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,962,006.00	3,438,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,220,393.00	859,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,502,179.00	8,126,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,950,992.00	124,590,755.00
210301	Гэрэл, цахилгаан	5,239,992.00	4,146,055.00
210302	Түлш, халаалт	112,655,000.00	119,707,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	737,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,894,139.00	9,643,189.00
210401	Бичиг хэрэг	1,381,400.00	876,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,408,150.00	1,199,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,277.00	1,044,774.00
210404	Ном, хэвлэл	1,876,744.00	823,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	509,268.00	2,034,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,883,300.00	3,665,075.00
2105	Нормативт зардал	39,701,330.00	26,253,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,873,300.00	3,042,100.00
210502	Хоол, хүнс	19,570,030.00	21,461,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,258,000.00	1,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,695,000.00	3,073,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,200,000.00	283,800.00
210602	Тавилга	5,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,695,000.00	2,789,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,448,000.00	350,000.00
210702	Дотоод албан томилолт	1,448,000.00	350,000.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,701,600.00	9,228,423.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,001,600.00	8,488,423.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,700,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,368,322.00	21,711,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,548,250.00	9,248,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,820,072.00	12,463,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,153,818.00	79,345,771.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,839,150.00	50,296,988.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,389,920.00	18,696,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,905,408.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,759,430.00	23,238,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,689,800.00	456,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,860,000.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,860,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,808.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,808.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,290,860.00	29,048,783.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,290,860.00	29,048,783.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	17,216,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	17,216,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	17,216,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	17,216,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	17,216,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-17,216,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,270,640,649.12	335,342,731.00	27,599,579.83	1,633,582,959.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,270,640,649.12	335,342,731.00	27,599,579.83	1,633,582,959.95
C07	Тайлант үеийн үр дүн	38,000,000.00	00.00	-279,215,202.92	-241,215,202.92
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-3,578,568.82	1,840,315,089.10
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-3,578,568.82	1,840,315,089.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	237,977,850.10	237,977,850.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	234,399,281.28	2,078,292,939.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-237,977,850.10	00.00	-237,977,850.10
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,005,479.74	23,005,479.74
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	297,275,158.70	257,404,761.02	1,863,320,568.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	955,919,200.00	924,947,872.00	30971328.00	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	955,919,200.00	924,947,872.00	30971328.00	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928,536,200.00	905,795,192.00	22741008.00	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	623,994,000.00	619,737,107.00	4256893.00	99.3
210101	Үндсэн цалин	409,408,300.00	406,747,609.00	2660691.00	99.4
210102	Нэмэгдэл	169,320,600.00	171,125,573.00	-1804973.00	101.1
210104	Урамшуулал	45,265,100.00	41,863,925.00	3401175.00	92.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,805,300.00	82,102,841.00	6702459.00	92.5
210201	Тэтгэврийн даатгал	68,606,100.00	65,424,341.00	3181759.00	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,049,700.00	4,254,300.00	795400.00	84.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,039,900.00	3,438,300.00	601600.00	85.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,000.00	859,400.00	150600.00	85.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,099,600.00	8,126,500.00	1973100.00	80.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,513,100.00	124,590,755.00	1922345.00	98.5
210301	Гэрэл, цахилгаан	5,745,100.00	4,146,055.00	1599045.00	72.2
210302	Тулш, халаалт	119,712,000.00	119,707,500.00	4500.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	737,200.00	318800.00	69.8
2104	Хангамж, бараа материалын зардал	10,390,600.00	9,643,189.00	747411.00	92.8
210401	Бичиг хэрэг	876,100.00	876,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,199,900.00	100.00	100.0
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,766,600.00	1,044,774.00	721826.00	59.1
210404	Ном, хэвлэл	826,900.00	823,000.00	3900.00	99.5
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,000.00	2,034,340.00	5660.00	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,681,000.00	3,665,075.00	15925.00	99.6
2105	Нормативт зардал	35,262,900.00	26,253,250.00	9009650.00	74.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,042,400.00	3,042,100.00	300.00	100.0
210502	Хоол, хүнс	30,469,000.00	21,461,150.00	9007850.00	70.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,751,500.00	1,750,000.00	1500.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,292,700.00	20,289,700.00	3000.00	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	17,500,000.00	17,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,792,700.00	2,789,700.00	3000.00	99.9
2107	Томиллолт, зочны зардал	401,800.00	350,000.00	51800.00	87.1
210702	Дотоод албан томиллолт	401,800.00	350,000.00	51800.00	87.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,137,800.00	1,117,200.00	20600.00	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,800.00	377,200.00	20600.00	94.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21738000.00	21711150.00	26850.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,250,000.00	9,248,000.00	2000.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,488,000.00	12,463,150.00	24850.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27383000.00	19152680.00	8230320.00	69.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,383,000.00	19,152,680.00	8,230,320.00	69.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,926,800.00	18,696,680.00	8,230,120.00	69.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	456,200.00	456,000.00	200.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	955,919,200.00	924,947,872.00	30971328.00	96.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	828,406,100.00	799,357,317.00	29,048,783.00	96.5
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	828,406,100.00	799,357,317.00	29,048,783.00	96.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	127,513,100.00	125,590,555.00	1,922,545.00	98.5
132001	Орон нутгийн төсвөөс	127,513,100.00	125,590,555.00	1,922,545.00	98.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54.00	54.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	04.00	04.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	490.00	476.00	14.00	97.1
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	490.00	476.00	14.00	97.1
630001	Төрийн өмчит ЕБС	490.00	476.00	14.00	97.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,619,430.00	37,255,531.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,619,430.00	37,255,531.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,000.00	6,111,223.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	6,111,223.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	6,111,223.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,619,430.00	31,144,308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,619,430.00	31,144,308.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,905,408.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,759,430.00	23,238,900.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,860,000.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,619,430.00	37,255,531.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,619,430.00	37,255,531.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,759,430.00	37,255,531.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,860,000.00	00.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал С.Цэгмид, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Ариунжаргал нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Өв соёлоо дээдэлсэн, тэгш оролцоот, амьдрах чадвартай, сургуулиараа бахарсан хүнлэг, иргэнийг бэлтгэнэ.
- Хүүхэд нэг бүрийг тэгш боломжоор ханган сургах, хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 973,026.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,595.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,216.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 10,640.2 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,394.7 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,374.5	136,516.6	16,142.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	12,860.7	95.7	(12,764.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	107,513.9	136,420.9	28,907.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,720,551.3	1,726,803.9	6,252.6
Үндсэн хөрөнгө	1,967,428.2	2,035,158.9	67,730.6
Хуримтлагдсан элэгдэл	(246,876.9)	(308,354.9)	(61,478.0)
Нийт хөрөнгө	1,840,925.9	1,863,320.6	22,394.7
Өр төлбөр	610.8	-	(610.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,840,315.1	1,863,320.6	23,005.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,840,925.9	1,863,320.6	22,394.7

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 12,764.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 12,860.7 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулсан бол тайлант онд ажиллагсадтай холбоотой 95.7 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 136,420.9 мянган төгрөг болж 28,907.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл 13,085.2 мянга, эм боох материал дансны үлдэгдэл 521.0 мянга, бичиг хэргийн материал дансны үлдэгдэл 1,221.7 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 9,707.5 мянга, хүнсний материал дансны үлдэгдэл 1,246.6 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 9,485.9 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,035,158.9 мянган төгрөг болж өмнөх оноос 67,730.6 мянган төгрөгөөр өссөн нь 31,351.2 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, хандив тусламжаар 24,594.4 мянга, үнэ төлбөргүй 11,785.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн данс 610.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн ажиллагсадтай холбоотой 610.8 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд төлсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,863,320.6 мянган төгрөг болж 23,005.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 23,005.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх зардлыг 970,308.2 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлыг 144,237.2 мянга, нийт зарлагыг 1,114,545.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 275,4848.8 мянган төгрөгөөр бууруулж 839,060.6 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 955,919.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 828,406.1 мянга, орон нутгийн төсвөөс 125,590.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 924,947.9 мянган төгрөгийг зарцуулж 29,048.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 924,947.9 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,959.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,922.3 мянга, нормативд зардлыг 9,009.6 мянга, үдийн цайны зардлыг 8,230.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,013,352.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 40,326.1 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 827,643.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 01 дүгээр сар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээтэй холбоотой 15,033.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 836,060.6 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 116,858.6 мянган төгрөг нэмж 828,406.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 127,513.1 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 924,947.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 3.2 хувийн хэмнэлт гаргасан.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 265,910.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 22,790.6 мянган төгрөг хасаж 243,119.9 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 223,107.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 16.1 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 876.1 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 876.1 мянган төгрөг зарцуулсан байна.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 134,493.1 мянган төгрөгөөр, тодотголоор 126,513.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 124,590.8 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 9,902.3 мянган төгрөг буюу 7.4 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,463.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 16,463.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 тоот захирамжаар тус байгууллагын төсөвт зардлыг нэмэгдүүлэн багаж техник хэрэгсэл худалдах авах зардлын төсвийг 17,500.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 10,000.0 мянга төгрөгөөр нэмэгдүүлж зохицуулалт хийсний дагуу Санка Маркетинг Монголиа ХХК-иас 9900.0 мянган төгрөгийн ухаалаг самбар, Тулга техник ХХК-иас 17500.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авсан байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 754.9 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 168.3 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 586.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой авлагыг 52470 төгрөгөөр дутуу, өглөгийг 115812 төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын гишүүдэд 2021 оны 07 дугаар сард үр дүнгийн урамшууллаас гадна цалингийн сангаас холбогдох шийдвэргүйгээр 586.6 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.5 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар төлбөрийн акт тогтоож төлүүлсэн.

4.3 Зөвлөмж

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 01 дүгээр сард цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 15,033.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Галуут сумын ерөнхий боловсролын сургууль	3	754.9	1	168.3	1	586.6		-	1	-

_____оОо_____